

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ, ХИМИЙН БОЛОН АЮУЛТАЙ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ДУУДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН ДАГУУ АЖИЛЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

ACCORDING TO POLICE DEPARTMENT CALLS RELATING TO EXPLOSIONS,
CHEMICAL OR HAZARDOUS SUBSTANCES SOME PROBLEMS TO CONSIDER IN
OPERATION

*Б.Баянмөнх
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Тэсэрч дэлбэрэх, химийн болон аюултай бодисын осол нь химийн аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэх явцад гэмтэл гарах, технологийн горим зөрчигдөх зэргийн улмаас химийн болон аюултай бодис алдагдаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд ноцтой аюул учирдаг үзэгдэл юм.

Энэхүү өгүүлэлд тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодисын тухай ойлголт, түүний илрэх шинж, химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтаас үүдэлтэй гарч болох дэлбэрэлт, түүний хор уршиг, цагдаагийн алба хаагчаас химийн хорт болон аюултай бодистой холбоотой дуудлага мэдээллийн дагуу авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар товч авч үзсэн болно.

Abstract: Explosive, chemical and hazardous substance accidents are phenomena in which chemical and hazardous substances are lost due to damage during the storage, transportation, and use of hazardous chemical substances in production, as well as violations of technological procedures, which pose a serious threat to the environment and human health.

In this article, the concept of exploding, toxic and dangerous chemicals, their manifestations, explosions that may occur due to the storage and protection of toxic and dangerous chemicals, their consequences, the actions taken by police officers in response to calls related to toxic and dangerous chemicals, measures are briefly discussed.

Түлхүүр үгс: Химийн бодис, аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэрэлт, хор уршиг, цагдаагийн алба хаагч, ослын дуудлага мэдээлэл

Keywords: Chemicals, dangerous substance, explosives, explosion, damage, police officers and emergency call information

Дарь, тэсрэх бодис нь маш богино хугацаанд асар их хор хохирол учруулах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул тарих, аюулын өндөр эрсдэл бүхий химийн хорт бодисын нэгдэл учир хүн бүрээс хатуу чанд сахилга бат, өндөр хариуцлага, дэлхий нийтийн жишигт дүйцэхүйц дүрэм, стандарт, хэм хэмжээг дагаж мөрдөхийг шаарддаг.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹⁷¹, Байгаль орчныг хамгаалах тухай хууль¹⁷², Зөвшөөрлийн тухай¹⁷³, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль¹⁷⁴, Хог хаягдлын тухай

¹⁷¹ Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1992. №1.

¹⁷² Байгаль орчныг хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1995. №5-6.

¹⁷³ Зөвшөөрлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2022. №38.

¹⁷⁴ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2012. №22.

хууль¹⁷⁵, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль¹⁷⁶, Гамшгаас хамгаалах тухай хууль¹⁷⁷, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрддэг.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1-д химийн аюултай бодистой холбоотой нэр томъёог дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал:

- “химийн хорт бодис” гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “химийн аюултай бодис” гэж тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “хориглосон химийн бодис” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглэхийг хориглосон химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “хязгаарласан химийн бодис” гэж зөвхөн зөвшөөрсөн газарт, заасан зориулалт, хэмжээ, технологийн дагуу тодорхой хяналтын дор хэрэглэхийг зөвшөөрсөн химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “пестицид” гэж мал, амьтан, ургамлыг аливаа өвчнөөс сэргийлэх, хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах зориулалттай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг¹⁷⁸ хэмээн тодорхойлжээ.

Харин Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлд “тэсэрч дэлбэрэх бодис” гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг¹⁷⁹ хэмээн тодорхойлжээ.

ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам” /код 211/-д тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт бодис, цацрагт идэвхт бодисын хөнөөл, химийн осол гэсэн нэр томъёонуудыг тодорхойлжээ. Тухайлбал:

- “Тэсэрч дэлбэрэх бодис” - тэсрэлтийн хүчийг ашиглах зориулалттай гадны хүчний үйлчлэлээр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хор хөнөөл учруулах аюултай химийн нэгдэл буюу механик хольцыг;

- “Химийн хорт бодис” - хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “Цацраг идэвхт бодис” - ураны хүдрээс илүү хүчтэй туяа цацруулдаг, химийн элементийн “Радий”-ийн төрлийн бодисуудыг;

- “Цацраг идэвхт бодисын хөнөөл” - цөмийн төхөөрөмжийн технологийн аюулгүй байдал алдагдсаны улмаас гамма ба бета төрлийн цацраг идэвхт бодисууд хий, шингэн, аэрозоль хэлбэрээр алдагдан гадаад орчинд /хүрээлэн буй орчинд/ цацагдахыг цацрагийн хөнөөлийг;

- “Химийн осол” - химийн аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэх явцад гэмтэл гарах, технологийн горим зөрчигдөх зэргийн улмаас химийн бодис алдагдаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулах үзэгдлийг¹⁸⁰ хэмээн тус тус тодорхойлжээ.

¹⁷⁵ Хог хаягдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017 №21.

¹⁷⁶ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.

¹⁷⁷ Гамшгаас хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017. №7.

¹⁷⁸ Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2006. №25.

¹⁷⁹ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.

¹⁸⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2022. 419 дэх тал

Гэвч дээрхи хууль, эрх зүйн актуудад аюултай бодис гэж юуг ойлгох талаар нарийвчлан тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолт байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

Химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь 1. хортой; 2. аюултай гэж тус тус ангилна.

Өнөөдөр террорист байгууллага, хувь хүмүүс нь олон нийтийг айдаст автуулсан мэдээлэл цацах, мэдээлэл технологийн сүлжээнд халдах /хакер/, хүн, объект, тээврийн хэрэгсэл барьцаалах, хууль бус жагсаал цуглаан зохион байгуулж, үймээн самуун бий болгох, тэсэрч дэлбэрэх, химийн болон аюултай бодис, тэсрэх бөмбөгийг олон нийтийн газар болон онц чухал объектод тавих зэрэг олон нийтийг айдас хүчирхийлэлд оруулах маш олон арга хэрэгсэл ашиглаж байна.

Тэсрэх бодис, тэсрэх бөмбөг аюулгүй болгох нь ажиллагаа нь тусгай зориулалтын техник хэрэгсэл болох робот, хувцас, дуулга, соронзонгүй багаж, уураг, зөөврийн рентген төхөөрөмж, үйлдвэрийн зориулалттай тэсрэх цэнэг зэргийг бэлтгэсэн байхын зэрэгцээ тусгай мэдлэг эзэмшсэн, техник хэрэгслийг ажиллуулж чадах мэргэжлийн тусгай мэдлэгтэй, мэргэшсэн алба хаагч хэрэгтэй болно.

Хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулж, үйлдвэрийн барилга, байгууламжийг эвдэх, тоног төхөөрөмж, механизм, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг гэмтээх устгах, үйл ажиллагааны хэвийн хэмжээг алдагдуулж, хүрээлэн буй орчинд хохирол учруулах, аюул үүсгэж болзошгүй үйлдвэр, тээвэр, холбоо, нийгэм, эрчим хүчний сүлжээ, зам тээврийн харилцаанд гарсан аюултай нөхцөл байдлыг үйлдвэрийн осол гэнэ.

Тэсрэх бодис химийн урвалд орж асар их хурдтай нэг байдлаас нөгөө төлөвт шилжихэд их хэмжээний хий, уур үүсч, дулаан ялгаран түүний потенциал энерги нь хүрээлэн буй орчныг бутлах, механик ажилд шилжих процессыг тэсрэлт гэнэ. Тэсрэлт нь дараах орчинд явагдаж болно. Тухайлбал: а)Газар доорхи; б)Газар дээрхи; в)Агаарт; г)Өндөрт; д)Усан доорхи; е)Усан дээрхи зэрэг болно.

Тэсрэх бодисын тэсрэлтийн үед их хэмжээний (300-1000 л/кг) хий уур үүсч, асар их дулаан (600-1700 ккал/кг) ялгаран гарах ба тэсрэлтийн температур 1500-4100 С хүрч, 8000 м/с түүнээс их хурдтай химийн урвал явагдан түүнийг дагалдан их дуу чимээ гардаг.

Тэсрэлтийг шинж чанараар нь физикийн, химийн, цөмийн гэж ангилдаг. Физикийн шинжтэй тэсрэлтийн үед бодист зөвхөн физик өөрчлөлт /цахилгаан цэнэг мөргөлдөн тэсрэх гэх мэт/ явагддаг. Химийн шинжтэй тэсрэлтийн үед химийн урвал явагдан эгшин зуурын хугацаанд хий уур үүсгэн дулаан ялгаруулна. Цөмийн болон халуун цөмийн шинжтэй тэсрэлтийн үед цөмийн хуваагдлаар шинэ элемент үүсэн цөмийн гинжин урвал явагдах ба энэ нь хамгийн хүчтэй тэсрэлт юм.¹⁸¹

Тэсрэлтийн үйлчлэлийн бүсийг детонцын долгионы, бүтээгдэхүүний тэсрэлтийн, агаарын цохилтын үйлчлэлийн бүс гэж гурав хуваадаг. Тэсрэлт нь доорхи гурван үндсэн нөхцөл бүрдсэн үед үүсдэг. Үүнд:

1. Агаар;
2. Шатах хий болон шатамхай тоос;
3. Хангалттай дөллөн асах эх үүсвэр;

Шатамхай хий нь агаартай нэгдэхэд тэсрэх аюултай холимог үүсдэг ба энэ холимог нь хангалттай дөллөн асаах эх үүсвэрийн улмаас (гал, дөл, дулаан, оч, цахилгаан тоног төхөөрөмжөөс үүсэх оч, тэнцэл цахилгаанаас үүсэх оч, халсан болон улайссан гадаргуу гэх мэт) тэсрэлт үүсдэг.

Тэсрэх аюултай объект гэдэг нь тэсрэх аюултай бодисыг хадгалах, хэрэглэх, ашиглах, зөөвөрлөх, тээвэрлэх зэрэг технологи ажиллагаа явуулдаг объектыг хэлнэ. Тэсрэх аюултай объектын орчныг Бүс-0, Бүс-1, Бүс-2 гэж гурав ангилдаг байна.

¹⁸¹ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -УБ., 2018. 250-251 дэх тал.

- Бүс-0 тоног төхөөрөмжийн ашиглалтын үед тэсрэх аюултай хийн хольц байнга буюу удаан хугацаагаар ялгарч байдаг

- Бүс-1 тоног төхөөрөмжийн ашиглалтын хэвийн ажиллагааны үед тэсрэх аюултай хийн хольц нь ялгарч байдаг тоног төхөөрөмж бүхий газар

- Бүс-2 тоног төхөөрөмжийн ашиглалтын хэвийн ажиллагааны үед тэсрэх аюултай хийн хольц нь ялгарч болзошгүй буюу хийн хольц хоромхон хугацаанд ялгарч байдаг.

Тэсрэх аюултай бүс гэдэг нь тэсрэх аюултай холимогтой буюу тэсрэх аюултай холимог бүрдэж буй өрөө, тасалгаа болон хязгаарлагдмал орчин, гадаа орших тоног төхөөрөмжийг хэлнэ.¹⁸²

Химийн, хийн, нефтийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанд төрөл бүрийн шатах шингэн /бензин, техникийн масло, спирт/, хий /аммиак, устөрөгч, ацетилен, пропан/, хатуу материал /нүүрс, хүхэр, фосфор/-ыг өргөнөөр хэрэглэдэг. Мөн өндөр температур, даралттай холбоотой технологи үйл ажиллагаа явуулдаг. Энэ бүх технологи үйл ажиллагаа нь гал болон тэсрэх аюултай нөхцлийг бүрдүүлдэг. Түүнчлэн хий, шингэн нь химийн аюултай бодисоос бүрдэж байдаг учраас тэсрэх аюулыг бүрдүүлнэ. Уг тэсрэлтээс үүдэлтэй гал гарах аюул улам нэмэгддэг.

Гал нь шатах материал болон бодис, дулааны эх үүсвэр (шүдэнз, лаа, цахилгаан, химийн урвал гэх мэт), хүчилтөрөгч (агаар) гурвын харилцан үйлчлэлээр бий болдог, гэрэл, дулаан ялгаруулдаг физик, химийн үзэгдэл юм.¹⁸³

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь аюулгүй байдлын судлагдахууны хувьд эрсдэлтэй хүчин зүйлд тооцогддог байна. Өнөөдөр цэргийн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа тэсрэх бодис, ахуйн хэрэглээнд ашиглаж байгаа хийний эрсдэлийн үнэлгээг гаргах нь чухал юм.

Өнөөдөр цагдаагийн алба хаагчид тэсрэх бодис болон химийн хорт бодисын урвалаас үүсэх тэсрэлтийн талаар нэлээн өргөн мэдлэгтэй байж, эрсдлийн үнэлгээ хийж чаддаг байх нь болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн чухал ач холбогдолтой юм.

Эрсдлийн үнэлгээ гэж “химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийн нэгдэлтэй харьцах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг судлан тогтоож, үнэлгээ өгөх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар авах арга хэмжээг тодорхойлохыг”¹⁸⁴ ойлгоно. Эрсдэлийн үнэлгээ нь дараах үйл ажиллагаануудын нийлбэр цогц юм. Үүнд:

- Аюулыг таних;
- Холбоотой эрсдлийг шинжлэн үнэлэх;
- Аюулыг арилгах эсхүл хянах тохиромжтой хэлбэрийг сонгох;

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь тэсэрч дэлбэрэх, химийн хорт бодистой холбоотой мэдээлэл хүлээн аваад дээр дурдсан үйл ажиллагаануудыг системтэйгээр зөв авч хэрэгжүүлж чадсанаар учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх, уг аюулыг хянах арга хэмжээ нь тохиромжтой эсэхийг тодорхойлох, сэжиг бүхий нуугдмал аюулыг илрүүлэх, олон нийтийг эрсдэлд өртөх боломжийг тодорхойлох, аюул болон хяналтын арга хэмжээний дарааллыг тодорхойлох зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Мэдээлэл хүлээн авч тухайн газарт эхлэн очсон алба хаагч ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам” /код 211/-ийн 211.4.1-д заасны дагуу дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэхээр зохицуулжээ. Үүнд:

¹⁸² “Тэсрэх дэлбэрэх бодисын хэрэглээ, түүнд тавигдах шаардлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл. -УБ., 2014. 50 дахь тал

¹⁸³ Байгалмаа, П. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье. -УБ., 2011. 4-5 дахь тал.

¹⁸⁴ Төрийн мэдээлэл. 2013. №8. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль.

- а/ тэсэрч дэлбэрэх зүйл, химийн бодис болон цацраг идэвхт байж болзошгүй зүйлд өөрөө болон бусдыг хүргэхгүй байх;
- б/ дэлбэрэлтийн бүсийн эргэн тойронд 200 метр, химийн осол болон цацраг идэвхт бодисын хөнөөлийн үед 300-500 метрээс доошгүй зайд хамгаалалтын бүс тогтоож, иргэдийг бүсээс гаргаж, бүслэн хамгаалах;
- в/ тухайн зүйлийн байршил, орчин, хэмжээ, хэлбэр, төрөл, өнгө, үнэр зэрэг гадаад шинж тэмдэг, учирсан болон болзошгүй хор уршиг, аюулын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Шуурхай удирдлагын штабт мэдэгдэх;
- г/ тухайн газраас 300 алхмын дотор радио долгионы хэрэгсэл ашиглахгүй байх;
- д/ ойролцоо газар, тухайн нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодис байгаа эсэхийг шалгах¹⁸⁵.

Цагдаагийн алба хаагч нь Зэвсэгт хүчин, Эмнэлгийн яаралтай тусламж, Онцгой байдлын алба зэрэг ажил үүргийнхээ дагуу хамгаалалтын бүсэд нэвтрэх шаардлагатайгаас бусад байгууллага, албаны хүнийг тухайн бүсэд нэвтрүүлэхийг хориглоно. Цагдаагийн алба хаагч нь тэсэрч дэлбэрэх зүйл, химийн хорт болон цацраг идэвхт бодистой холбоотой мэдээллийн дагуу очихдоо “Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам” /код 918/-д заасны дагуу хамгаалах тусгай хэрэгслийг хэрэглэнэ.

Цагдаагийн алба хаагч тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой үүсч буй аюулыг таньж илрүүлэхийн тулд уг аюулын илрэх хэлбэр, онцлог шинжийн талаар мэдлэгтэй байх, уг бодистой харьцах аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөхөөс гадна биечлэн аюулгүй болгох арга хэмжээ авч болохгүйг онцгой анхаарна.

Цагдаагийн алба хаагч химийн осол болон цацраг идэвхт бодисын хөнөөлийн үед ажиллахдаа “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам” /код 211/-ийн 211.5-д заасныг баримтлан мэргэжлийн байгууллагаар тухайн бодисын алдагдсан болон тархалтын хэмжээ, сөрөг нөлөөг тогтоолгосны дараа өөрсдийгөө болон оршин суугчдын аюулгүй байдлыг хангах үүднээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- а/мэргэжлийн байгууллагын өгсөн зааврын дагуу ажиллах;
- б/хамгаалалтын бүсэд голомтод ажиллах мэргэжлийн байгууллагынхаас өөр гадны хүнийг нэвтрүүлэхгүй байх;
- в/хамгаалах хувцас өмсөх, газ эсэргүүцэгч, хүчилтөрөгчийн баг хэрэглэх, хэрэв баг байхгүй тохиолдолд нойтон алчуураар ам, хамраа дарах;
- г/хордсон болон гэмтсэн иргэдэд тусламж үзүүлэх; д/оршин суугчдыг нүүлгэн шилжүүлж эхлэх хэрэв сайн дураараа нүүхгүй бол албадан нүүлгэх.¹⁸⁶

Тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой мэдээлэл хүлээн авч тухайн газарт эхлэн очсон алба хаагч дор дурьдсан ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Дэлбэрэлт болсон газрын байршил, хор уршгийн тархалт, хамарсан нутаг дэвсгэрийн хэмжээ, бэртэж, гэмтсэн иргэдийн тоо, эвдэрч гэмтсэн барилга байгууламжийн ерөнхий байдал, бусад нөхцөл байдлын талаарх мэдээллийг Шуурхай удирдлагын албанд эргэж мэдэгдэн нэмэлт тусламж хүсэх;
- Тэсэрч дэлбэрэх бодис, занга тавьсан байж болзошгүйг анхаарч, сэжигтэй зүйл илэрвэл түүнд хүрэхгүй, орчны хүмүүсийг нэн даруй холдуулж, шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг шуурхай удирдлагын албанд яаралтай мэдэгдэх;
- Дэлбэрэлт болсон газар луу өөрөө болон бусад иргэдийг ойртуулахгүй байх арга хэмжээ авч, дэлбэрэлт болсон газрыг бүхэлд нь буюу төв цэгээс 50-200 метрийн тойрогт хамгаалалтын бүс байгуулж, нэмэлт хүч иртэл иргэдийг аюулгүй газар гаргах ажлыг зохион байгуулах;
- Дэлбэрэлтийн улмаас бэртэж, гэмтсэн, хордсон иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;

¹⁸⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2022. 420 дахь тал.

¹⁸⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2022. 420 дахь тал.

- Хэргийн газрын үзлэгийн багийг хүрэлцэн иртэл цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан устаж, баларч болох ул мөрийг хамгаалах арга хэмжээ авах;
- Хамгаалалтын нэмэлт хүч иртэл дэлбэрэлт болсон газрын ойролцоох аж ахуйн нэгж, байгууллагын харуул, жижүүр, хамгаалалтын ажилтнуудыг хамгаалалтанд татан оролцуулах;
- Зэвсэгт хүчин, Эмнэлгийн яаралтай тусламж, Онцгой байдлын алба зэрэг ажил үүргийнхээ дагуу хамгаалалтын бүсэд нэвтрэх шаардлагатайгаас бусад байгууллага, иргэнийг хамгаалалтын бүс рүү нэвтрүүлэхгүй байх;
- Дэлбэрэлт болсон газраас 300 алхмын дотор радио долгионы хэрэгсэл ашиглахгүй байхыг анхаарч ажиллах;
- Дэлбэрэлт болсон газрын ойролцоо нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодис ашигладаг, хэрэглэдэг, хадгалдаг байгууллага, аж ахуйн нэгж байгаа эсэхийг тодруулж, сэрэмжлүүлэх;
- Дэлбэрэлтийг үйлдсэн байж болох сэжигтэй этгээд болон анхлан харсан гэрчийг олох зорилгоор биечилсэн судалгаа явуулах;¹⁸⁷

Химийн осол гарсан үед авах арга хэмжээ

Химийн ослын аюул нь хүн ба амьтанд организмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, удах тусам бие махбодийн генетик бүтцэд сөргөөр нөлөөлдөг, харин химийн аюултай бодис организмд амьсгалын замаар, арьсаар, салст бүрхүүлээр болон хоол хүнстэй хамт орсон үедээ үхэлд хүргэх аюултай байдаг.

Химийн осол гэдэг нь химийн аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэх явцад гэмтэл гарах, технологийн горим зөрчигдөх зэргийн улмаас химийн бодис алдагдаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулах үзэгдэл юм.¹⁸⁸

Хлор, аммиак, фосген, цианы хүчил, хүхэрт ангидрид зэрэг химийн аюултай бодисыг ихэвчлэн химийн, ислэг-цаасны, боловсруулах, эрдэс бордооны, хар болон өнгөт металлург, хөргөх, пивоны, чихрийн үйлдвэр, ус дамжуулах станц зэрэгт түгээмэл хэрэглэнэ.

Ажлын байрандаа ажиллаж байсан цагдаагийн алба хаагчид химийн ослын тухай “Бүгд анхаар” дохионы үед химийн ослын талаар илүү их мэдээ, мэдээлэл хүлээн авч байх үүднээс телевизор, радио асаалттай байлгах шаардлагатай.

Харин химийн аюултай бодис алдагдсан тухай анхны мэдээллийг хүлээж авсан цагдаагийн алба хаагч нэн даруй ослын газар очин тухайн орчинд ажиллаж амьдарч байгаа иргэдэд яаралтай мэдэгдэж, яарч сандралгүйгээр химийн аюултай бодис алдагдсан голомтын бүсээс салхины чиглэлд перпендикуляраар¹⁸⁹ гарч, уг голомтын төв цэгээс 1.5 км-ээс багагүй зайтай аюулгүй газарт хүргэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч химийн ослын газарт очихдоо амьсгалын эрхтэнээ хамгаалах үүднээс хорт хийнээс хамгаалах баг ашиглах бөгөөд байхгүй тохиолдолд хөвөн маарлан боолт юм уу ямар нэгэн даавуу 2-5 процентийн нимбэгний болон цууны хүнсний содын уусмалаар /хлороос хамгаалахад/ норгох, 2-5 процентийн нимбэгний болон цууны хүчлийн уусмалаар /аммиакаас хамгаалахад/ норгож хэрэглэнэ.

Цагдаагийн алба хаагч ослын бүсэд ажиллаж байгаад бүсээс гарах боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд хаалга, цонх, агааржуулах хоолой, яндан зэрэг агаар нэвтрэх боломжтой сувгуудыг сайтар хааж, ямарваа зай завсрыг цаас болон скочоор бөглөх шаардлагатай.

Төмөр зам, авто зам дээр химийн аюултай бодисын тээвэрлэлтэд осол тохиолдсон үед аюултай бүсийг осол болсон газар буюу голомтын төв цэгээс 200

¹⁸⁷ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -УБ., 2018. 250-255 дахь тал.

¹⁸⁸ Баттогтох, П., Баяржаргал, Б. Гамшиг, ослоос хамгаалах тухай гарын авлага. -УБ., 2006. 40 дэх тал.

¹⁸⁹ Энэ нь салхины дагуух чиглэлийн хөндлөн зүгт гарахыг ойлгоно.

метрийн радиустайгаар тогтоож, нийтэд илт мэдэгдэхээр таних тэмдэг тавьж сэрэмжлүүлэх шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч химийн аюултай бодист хүрсэн байж болох сэжиг илэрсэн тохиолдолд их хэмжээний шингэн /цай, сүү/ ууж, нэн даруй ойролцоох эмнэлгийн байгууллагад очих хэрэгтэй.¹⁹⁰

Дүгнэлт

Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага мэдээлэл харьцангуй бага ирдэг боловч хэрэв гэнэт ирвэл хэрхэн биеэ бэлтгэж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх вэ гэсэн асуудалд анхаарлаа хандуулах цаг болжээ.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлагаас тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс жил бүр онцгой байдлын мэргэжлийн байгууллага, алба хаагчдаар сургалт зохион байгуулж явуулах, алба хаагчдаа чадавхижуулах, арга зүйг тогтмол зааж сургаж байх шаардлага бий болжээ.

Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага мэдээлэл харьцангуй бага ирдэг, нөгөө талаараа бодистой холбоотой харилцаа нь олон хууль, эрх зүйн актуудаар зохицуулагдаж байгаа нь цагдаагийн алба хаагчдын эрх зүйн мэдлэг, бодистой харьцах арга зүйн туршлага дутах нөхцлийг бүрдүүлж байна.

Санал

Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ЦЕГ-ын даргын баталсан “Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу ажиллах журам” /код 211/-д “Аюултай бодис” хэмээх нэр томъёоны тодорхойлолтыг шинээр боловсруулж, оруулах;

2. Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу ажиллах цагдаагийн алба хаагчийн эрх зүйн мэдлэг, арга зүйн чадварын түвшинг тогтоох шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа авч цаашид явуулах сургалтынхаа чиглэлийг тодорхой болгох;

3. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын алба хаагчдад тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу ажиллахад шаардлагатай эрх зүйн мэдлэг олгох, арга зүйн чадвар суулгах практик сургалтыг онцгой байдлын албатай хамтран жил бүр зохион байгуулж явуулах.

Ашигласан материал

Хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1992. №1.
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1995. №5-6.
3. Зөвшөөрлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2022. №38.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2012. №22.
5. Хог хаягдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017 №21.
6. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.
7. Гамшгаас хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017. №7.
8. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2006. №25.

¹⁹⁰ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -Уб., 2018. 257 дахь тал.

9. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.

Ном, сурах бичиг:

10.Баттогтох, П., Баяржаргал, Б. Гамшиг, ослоос хамгаалах тухай гарын авлага. -Уб., 2006.

11.Байгалмаа, П. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье. -Уб., 2011

12.Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -Уб., 2018.

13.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -Уб., 2022.